



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН  
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/18/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn  
Аудитын менежер: С.Нацагдорж  
Утас: 261885 Цахим хаяг: natsagdorjs@audit.gov.mn  
Ахлах аудитор: Д.Болор-Эрдэнэ  
Утас: 261740 Цахим хаяг: bolorderned@audit.gov.mn  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ашид баланс аудит ХХК  
Захирал: Л.Майцэцэг  
Утас: 99081568 Цахим хаяг: ashidbalance@gmail.com

Улаанбаатар хот  
2022 он

**Агуулга**

1. Аудитын санал дүгнэлт .....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл .....	8
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Дотоод хяналт .....	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
4.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	10
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	10
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	11
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	14
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	14
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	15
8. Аудитын илрүүлэлт.....	15
8.1 Залруулсан алдаа.....	16
8.2 Төлбөрийн акт .....	16
8.3 Албан шаардлага.....	17
8.4 Зөвлөмж.....	17
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	20

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
ОУНБ	Олон улсын нисэх буудал
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ҮХЭХАТ	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ  
ТӨВИЙН ДАРГА П.МӨНХЖАРГАЛ  
ТАНАА

2022.03.15 № 07/610  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын санал дүгнэлт

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй 418.3 сая төгрөгийн зөрчил илэрч тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5, 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.2.5, Нийцсэн бөгөөд зохистой байх, Тохиолдсон байх, Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### Асуудлыг онцолсон зүйл

Иргэний нисэхийн үндэсний төвийн орлого, зарлагын төлөвлөгөөг Зам, тээврийн хөгжлийн сайд болон Сангийн сайдын хамтарсан тушаалаар баталдаг. Төвийн орлогын төлөвлөгөөнд навигацийн орлогыг баталдаг боловч Иргэний нисэхийн ерөнхий газрын дансанд уг орлогыг төвлөрүүлэн зарцуулж байна. Навигацийн орлого Иргэний нисэхийн үндэсний төвийн тайланд тусгагдахгүй, Иргэний нисэхийн ерөнхий газрын нэгтгэсэн тайланд тусгагдаж байна.

### Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар тус төвийн орлого, зарлагын төлөвлөгөөнд орлогыг 237,464.1 сая төгрөг, зарлагыг 162,538.5 сая төгрөг байхаар баталсан байна.

Үүнээс Иргэний нисэхийн ерөнхий газрын төсвийн хуваарилалтаар Иргэний нисэхийн үндэсний төвийн нийт орлогыг 8,206.3 сая төгрөг, нийт зардлыг 140,393.9 сая төгрөг, зөрүү зарлагын эх үүсвэрийг Иргэний нисэхийн ерөнхий газраас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр нийт 8,578.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн, 119,819.5 сая төгрөгийн санхүүжилт авч, 107,624.8 сая төгрөгийн зардал гаргасан байна.

Тус төвийн орлогын гүйцэтгэл 8,578.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 372.2 сая төгрөг буюу 4.5 хувиар давсан нь буулт хөөрөлтийн орлого болон бусад орлогын өсөлт голлон нөлөөлсөн байна.

### **Бусад мэдээлэл**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 17 зорилтын хүрээнд 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

			/төгрөгөөр/	
Код	Балансын үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31	
1	<b>ХӨРӨНГӨ</b>			
1.1	<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	6,734,278,371.66	2,653,064,653.58	
1.1.2	Дансны авлага	15,143,246,999.03	7,594,639,855.45	
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	2,709,413,144.76	79,444,172.36	
1.1.4	Бусад авлага	720,264,719.57	1,416,641,513.12	
1.1.6	Бараа материал	9,471,500,856.53	19,734,870,878.22	
1.1.7	Урьдчилж төлсөн зардал, тооцоо	243,837,176.47	1,004,912,064.06	
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө	5,547,500.00	5,547,500.00	
1.1.10	Системийн авлага	4,618,912,092.38	1,909,632,686.70	
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>39,647,000,860.41</b>	<b>34,398,753,323.48</b>	
1.2	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</b>			
1.2.1	Үндсэн хөрөнгө	166,161,046,731.99	160,926,657,357.50	
1.2.2	Биет бус хөрөнгө	360,032,430,152.65	362,051,355,809.56	
1.2.3	Дуусаагүй барилга	4,623,944,748.87	497,321,293.60	
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	1,302,860,535.99	1,802,600,638.37	
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>532,120,282,169.50</b>	<b>525,277,935,099.03</b>	
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>571,767,283,029.92</b>	<b>559,676,688,422.51</b>	
2	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>			
2.1	Өр төлбөр			
2.1.1	Богино хугацаат өр төлбөр			
2.1.1.1	Дансны өглөг	54,845,132.55	57,900,166.13	
2.1.1.2	Цалингийн өглөг	2,070,000.00	52,000.00	
2.1.1.3	Татварын өр	1,247,487,937.87	209,486,564.78	
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,088,444.71	120,500.00	
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	127,825,484.43	36,374,476.11	
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	636,738,296.67	443,362,865.35	
2.1.1.12	Системийн өглөг	8,362,718.00	2,095,770,173.40	
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>2,078,418,014.24</b>	<b>2,843,066,745.78</b>	
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	-	-	
2.1.2.4	УОО-Улсын хөрөнгө оруулалт	570,266,492.76	5,979,161,806.44	
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>570,266,492.76</b>	<b>5,979,161,806.44</b>	
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>2,648,684,507.00</b>	<b>8,822,228,552.22</b>	
2.3	Эздийн өмч			
2.3.1	Өмч: Төрийн	380,558,152,900.00	380,558,152,900.00	
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	30,066,263,133.29	30,066,263,133.29	
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,378,109,915.69	2,001,019,621.81	
2.3.9	Хуримтлагдсан ашиг/алдагдал	156,116,072,573.94	138,229,024,215.20	
	<b>Эздийн өмчийн дүн</b>	<b>569,118,598,522.92</b>	<b>550,854,459,870.30</b>	
2.4	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>571,767,283,029.92</b>	<b>559,676,688,422.51</b>	

## 2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Мөр	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого/цэвэр/	9,821,781,462.83	5,812,491,815.82
2	Борлуулалтын өртөг	121,419,595,833.39	112,811,693,286.95
3	<b>Нийт ашиг/алдагдал/</b>	<b>(111,597,814,370.56)</b>	<b>(106,999,201,471.13)</b>
4	Түрээсийн орлого	1,157,256,413.40	223,306,548.58
5	Хүүний орлого	250,236,880.27	67,506,322.41
8	Бусад орлого	414,835,247,379.53	253,289,536,611.04
11	Ерөнхий ба удирдлагын зардал	3,995,951,729.67	2,923,682,564.07
12	Бусад зардал	325,762,158,902.72	152,715,238,960.19
13	Гадаад валютын ханшны олз/гарз/	409,588,622.27	(6,415,883.07)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз/гарз/	(123,350,791.61)	(24,663,247.67)
18	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал/</b>	<b>(24,826,946,499.09)</b>	<b>(9,088,852,644.09)</b>
19	Орлогын татварын зардал	-	-
20	<b>Татвар дараах ашиг/алдагдал/</b>	<b>(24,826,946,499.09)</b>	<b>(9,088,852,644.09)</b>
28	<b>Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг/алдагдал/</b>	<b>(24,826,946,499.09)</b>	<b>(9,088,852,644.09)</b>

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг/алдагдал	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	379,258,502,900.00	27,462,418,471.27	2,715,872,210.32	126,956,108,209.71	536,392,901,791.30
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	379,258,502,900.00	27,462,418,471.27	2,715,872,210.32	126,956,108,209.71	536,392,901,791.30
Тайлант үеийн ашиг, алдагдал	-	-	-	(24,826,946,499.09)	(24,826,946,499.09)
Өмчит гарсан өөрчлөлт	1,299,650,000.00	2,603,844,662.02	(337,762,294.63)	53,986,910,863.32	57,552,643,230.71
<b>2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	380,558,152,900.00	30,066,263,133.29	2,378,109,915.69	156,116,072,573.94	569,118,598,522.92
Тайлант үеийн үр дүн	-	-	-	(9,088,852,644.09)	(9,088,852,644.09)
Өмчит гарсан өөрчлөлт	-	-	(377,090,293.88)	(8,798,195,714.65)	(9,175,286,008.53)
<b>2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл</b>	380,558,152,900.00	30,066,263,133.29	2,001,019,621.81	138,229,024,215.20	550,854,459,870.30

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>279,894,372,794.41</b>	<b>176,625,612,867.15</b>
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	9,883,302,207.23	2,765,051,566.41
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	125,077,313.14	28,135,979.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	5,088,384.00	9,994,714.50
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	142,280,021,121.65	147,101,331,227.60
1.1.6	Үйл ажиллагааны бусад мөнгөн орлого	127,600,883,768.39	26,721,099,379.64
1.1.6.1	Банк хоорондын гүйлгээ	-	846,217,158.47
1.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>287,907,809,860.05</b>	<b>179,853,915,617.60</b>
1.2.1	Ажиллагчдад төлсөн	65,002,303,219.82	59,393,407,101.89
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	16,464,246,043.79	15,118,604,466.09
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	4,761,603,018.86	4,746,602,201.01
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	5,206,661,705.12	5,339,338,095.67
1.2.5	Хүүний төлбөрт төлсөн	6,595,574.02	-
1.2.6	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	4,660,107,313.17	4,418,238,568.47
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	7,917,823,736.70	10,731,675,984.89
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	89,954,032.46	463,232,339.14
1.2.9	Үйл ажиллагааны бусад мөнгөн зардал	183,798,515,216.11	79,642,816,860.44
1.2.9.1	Банк хоорондын гүйлгээ	-	848,225,635.82
1.3	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(8,013,437,065.64)</b>	<b>(3,228,302,750.45)</b>
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	<b>Мөнгөн орлогын дүн (+)</b>	<b>249,283,176.90</b>	<b>67,291,688.51</b>
2.1.6	Хүлээн авсан хүүгийн орлого	249,283,176.90	67,291,688.51
2.2	<b>Мөнгөн зарлагын дүн (-)</b>	<b>541,646,272.70</b>	<b>920,202,656.14</b>
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	497,239,739.70	920,202,656.14
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,100,000.00	-
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	43,306,533.00	-
2.3	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(292,363,095.80)</b>	<b>(852,910,967.63)</b>
4	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(8,305,800,161.44)</b>	<b>(4,081,213,718.08)</b>
4	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(8,305,800,161.44)</b>	<b>(4,081,213,718.08)</b>
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>15,040,078,533.11</b>	<b>6,734,278,371.66</b>
6	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>6,734,278,371.66</b>	<b>2,653,064,653.58</b>



## 2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмж- их нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны		Зөрүү	Хувь
				Төлөв- лөгөө	Гүйцэтгэл		
1	<b>Үйлдвэрлэлийн үндсэн үзүүлэлт</b>						
	<b>Зорчигчийн тоо</b>	<b>хүн</b>	<b>447,478.0</b>	<b>134,110.0</b>	<b>198,523.0</b>	<b>64,413.0</b>	148.0
	Олон улс		161,804.0	43,470.0	100,256.0	56,786.0	230.6
	Орон нутаг		285,674.0	90,640.0	98,267.0	7,627.0	108.4
	<b>Ачаа</b>	<b>тонн</b>	<b>2,502.0</b>	<b>8,055.0</b>	<b>6,194.0</b>	<b>(1,861.0)</b>	76.9
	Олон улс		2,466.0	8,030.0	6,183.0	(1,847.0)	77.0
	Орон нутаг		36.0	25.0	11.0	(14.0)	44.0
	<b>Шуудан</b>	<b>тонн</b>	<b>239.0</b>	<b>351.0</b>	<b>236.0</b>	<b>(115.0)</b>	67.2
	Олон улс		177.0	300.0	231.0	(69.0)	77.0
	Орон нутаг		62.0	51.0	5.0	(46.0)	9.8
	<b>Нийт буулт, хөөрөлт</b>	<b>тоо</b>	<b>7,284.0</b>	<b>7,048.0</b>	<b>7,098.0</b>	<b>50.0</b>	100.7
	Олон улсын буулт, хөөрөлт		1,721.0	2,385.0	2,435.0	50.0	102.1
	Орон нутгийн буулт, хөөрөлт		5,563.0	4,663.0	4,663.0	-	100.0
2	<b>Нийт орлого</b>	<b>сая төгрөг</b>	<b>16,083.2</b>	<b>8,206.3</b>	<b>8,578.5</b>	<b>372.2</b>	104.5
	Үүнээс буулт, хөөрөлтийн орлого		3,954.5	1,246.2	1,276.8	30.6	102.5
	Зорчигч үйлчилгээний орлого		2,265.5	337.3	279.9	(57.4)	82.9
	Бусад орлого		9,863.2	6,622.8	7,021.8	399.0	106.0
3	<b>Нийт зардал</b>	<b>сая төгрөг</b>	<b>113,826.6</b>	<b>140,393.9</b>	<b>107,624.8</b>	<b>32,769.1</b>	<b>76.7</b>
	Үүнээс: Цалин, нэмэгдэл урамшуулал		75,095.1	80,667.1	66,235.5	(14,431.6)	82.1
	Ажил олгогчоос төлөх НДШ		9,727.7	10,764.0	8,851.1	(1,912.9)	82.2
	Ашиглалтын зардал		3,471.7	4,141.0	2,948.2	(1,192.8)	71.2
	Хангамж, бараа материалын зардал		4,188.9	4,858.0	3,558.9	(1,299.2)	73.3
	Нормативт зардал		618.7	738.3	257.5	(480.8)	34.9
	Эд хогшил, урсгал засварын зардал		3,936.9	6,234.0	2,999.3	(3,234.7)	48.1
	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл		860.3	1,423.6	731.2	(692.4)	51.4
	Томилолт, зочны зардал		721.5	770.0	507.2	(262.8)	65.9
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ		11,364.2	15,958.4	13,725.3	(2,233.1)	86.0
	Бусад зардал		3,841.6	5,366.2	1,656.0	(3,710.2)	30.9
Урсгал шилжүүлэг		-	9,473.3	6,154.6	(3,318.7)	65.0	

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд компанийн дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад Иргэний нисэхийн үндэсний төвийн хэмжээнд цагийн бүртгэлийн маягт болон цагийг нэгтгэн тооцох зааврыг баталж хэрэгжүүлэх, хөдөлмөрийн гэрээ дуусгавар болж байгаа ажилчидтай хаалтын тооцоог тойрох хуудсаар хяналт хийх, татвар, санхүүгийн тайлан уялдаатай байх, гэрээний дагуу урьдчилж төлсөн зардлыг хүлээн зөвшөөрөгдөх хугацаагаар нь бүртгэж тайлагнах, авлага, өглөгийг барагдуулах, хүлээж авсан хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаж бүртгэх, өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгийн асуудлаар өмч хамгааллын зөвлөлийн шийдвэр гаргуулах, анхан шатны баримтын бүрдүүлэлтийг сайжруулах, санхүүгийн программ хөгжүүлэлтийг тогтмол хийж хэрэглэгчийн эрхийн хязгаарлалтын хяналтыг сайжруулах, засгийн газрын 2016 оны 47 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллах, шилэн дансны болон төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах зэрэг зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 15-аас 2022 оны 3 дугаар сарын 15-ны хооронд Ашид баланс аудит ХХК-ийн захирал Л.Майцэцэг, ахлах аудитор Д.Гандолгор, аудиторын туслах Д.Сэрчинмаа нар гүйцэтгэж, хяналтыг чанарын хяналтын менежер Л.Оюунчимэг хэрэгжүүлсэн.

Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 10-1/190 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд харьяалах яамнаас хяналт шалгалт хийгээгүй, Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод аудитын албанаас тус төвийн Нисэхийн сургалтын төв, Оношилгоо, хэмжил зүйн лаборатори, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний алба, Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудитын хяналт шалгалтаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах талаар Газрын тусгай үйлчилгээ шатахуун хангалтын албанд 18, Нисэхийн мэдээллийн үйлчилгээний албанд 17, Нисэхийн сургалтын төвд 19, Оношилгоо хэмжил зүйн лабораторид 6 нийт 60 зөвлөмжийг өгч, хэрэгжилтэд хяналт тавьж ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “их” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлогын 45,939.3 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 229.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4. Санхүүгийн тайлангийн тодруулга**

### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Иргэний нисэхийн үндэсний төвийн зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэрт болон агаарын зайд нислэгийн аюулгүй ажиллагаа, нисэхийн аюулгүй байдлыг хангасан, дэлхийн тэргүүлэх жишигт нийцсэн, эдийн засгийн үр ашигтай агаарын навигаци болон нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, салбарын бодлоготой уялдуулан үйлдвэрлэлийн тогтвортой үйл ажиллагааг хангахад оршино.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн А/45 дугаар тушаалаар тус төвийн дүрмийг шинэчлэн баталсан байна. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг агаарын навигацийн үйлчилгээ, нисэх буудлын үйлчилгээ, үйл ажиллагааг дэмжих бусад үйлчилгээ үзүүлэх гэж тодорхойлжээ.

Иргэний нисэхийн үндэсний төв нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Иргэний нисэхийн ерөнхий газрын харьяа 6577539 тоот регистрийн дугаартай гэрчилгээтэй аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэсэн статустай байна. Өмчийн 100 хувийг төр эзэмшиж байна.

### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 387 дугаар тушаалаар Иргэний нисэхийн ерөнхий газрын бүтцийг шинэчлэн баталж, уг бүтцийн дагуу 2020 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс шинэ бүтэц, зохион байгуулалтаар Иргэний нисэхийн үндэсний төв нь ажиллаж эхэлсэн байна.

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн А/86 дугаар тушаалаар “Буянт-Ухаа” Олон улсын нисэх буудлын үйлдвэрлэлийн үйл ажиллагаа “Чингис хаан” Олон улсын нисэх буудалд шилжиж, Буянт-Ухаа Олон улсын нисэх буудлын үйл ажиллагааны чиг үүрэгт өөрчлөлт орсон тул Иргэний нисэхийн үндэсний төвийн бүтэц

зохион байгуулалтыг шинэчлэн 5 газар, 5 хэлтэс, 13 алба, 2 тасаг, бусад үйлдвэрлэлийн нэгжтэй 1918 орон тооны ажилтантай байхаар батлагдсан байна.

Иргэний нисэхийн үндэсний төв нь Төлөөлөн удирдах зөвлөлгүй, төвийн даргад зөвлөх эрхтэй даргын зөвлөлтэй байна.

Иргэний нисэхийн үндэсний төвийн даргын зөвлөл 9 хүний бүрэлдэхүүнтэй ажилладаг, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг хэвийн зохион байгуулах, байгууллагын үйл ажиллагааг удирдлага болон бодлогоор хангах, тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх зэргээр тус төвийн даргад туслан дэмжих байдлаар нэмэлт цалин, урамшуулал авдаггүй орон тооны бус зөвлөл ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн А/45 дугаар тушаалаар “Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрэм”-ийг шинэчлэн баталсан;
- Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулсан;
- ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”;
- ЗГ-ын 2021 оны 124 тоот тогтоол “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах босго үнэ шинэчлэн тогтоох тухай”;

#### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Иргэний нисэхийн үндэсний төвийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	6,734,278.4	2,653,064.7	(4,081,213.7)
Авлага	23,191,837.0	11,000,358.2	(12,191,478.8)
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	243,837.2	1,004,912.1	761,074.9
Бараа материал	9,471,500.9	19,734,870.9	10,263,370.0
Бусад эргэлтийн хөрөнгө	5,547.5	5,547.5	-
Үндсэн хөрөнгө	166,161,046.7	160,926,657.4	(5,234,389.3)
Биет бус хөрөнгө	360,032,430.2	362,051,355.8	2,018,925.6
Дуусаагүй барилга	4,623,944.7	497,321.3	(4,126,623.5)
Хойшлогдсон татварын хөрөнгө	1,302,860.5	1,802,600.6	499,740.1
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>571,767,283.0</b>	<b>559,676,688.4</b>	<b>(12,090,594.6)</b>
<b>Өр төлбөрийн дүн</b>	<b>2,648,684.5</b>	<b>8,822,228.6</b>	<b>6,173,544.0</b>
Богино хугацаат өглөг	2,078,418.0	2,843,066.7	764,648.7
УОО-Улсын хөрөнгө оруулалт	570,266.5	5,979,161.8	5,408,895.3
Эздийн өмч	569,118,598.5	550,854,459.9	(18,264,138.6)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>571,767,283.0</b>	<b>559,676,688.4</b>	<b>(12,090,594.6)</b>

Касс дахь бэлэн мөнгөний үлдэгдэл 0.7 сая төгрөг, банк дахь харилцах дансны үлдэгдэл 2,652.4 сая төгрөг байна.

Авлагын 11,000.4 сая төгрөгийн үлдэгдэлд ХХОАТ-ын авлага 32.2 сая төгрөг, НӨАТ-ын авлага 17.1 сая төгрөг, ҮХЭХАТ-ын авлага 1.3 сая төгрөг, НДШ-ийн авлага 28.9 сая төгрөг нийт 79.5 сая төгрөгийн татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 12,191.5 сая төгрөгөөр буурсан нь МИАТ ТӨХК-ийн 9,273.3 сая төгрөгийн авлагыг Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 370 дугаар тогтоолоор чөлөөлсөн, Буянт Ухаа олон улсын нисэх буудлын аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татварын нийт авлага 2,630.0 мянган төгрөгийг бусад татварын өглөгт хаасан нь нийт авлагын дүн буурахад нөлөөлсөн байна.

Тайлант онд урьдчилж төлсөн зардал, тооцоо дансанд хөрөнгийн даатгал, хариуцлагын даатгал, эрүүл мэндийн даатгал, нисэх буудал, навигацийн үйлчилгээний гуравдагч этгээдийн даатгалын төлбөр нийт 2,678.0 сая төгрөгийг шилжүүлж 1,004.9 сая төгрөгийг үлдэгдэлтэй байгаа нь 2022 онд хамааралтай даатгалын зардлууд бүртгэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 19,734.9 сая төгрөг болж 10,263.4 сая төгрөгөөр өссөн нь ТӨБЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 382 дугаар тогтоолын дагуу Иргэний нисэхийн ерөнхий газраас хүлээн авсан 5,273.1 сая төгрөгийн TES1 шатахуун, техник хангалтын зориулалтаар систем хооронд шилжсэн 4,990.3 сая төгрөгийн сэлбэгийн дотоод хөдөлгөөн нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Шинээр 7,396.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авсан, их засварын зардал 2,002.4 сая төгрөгөөр, ТӨБЗГ-ын 2021 оны 159 дүгээр тогтоолоор 279.1 сая төгрөгийн 2 тээврийн хэрэгслийг балансаас баланст, 72.5 сая төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгөөс ТӨБЗГ-ын 2021 оны 313, 320, 325, 515 дугаар тогтоолоор нийт 2,216.6 сая төгрөгийн өртөгтэй, 2,191.6 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 579 ширхэг хөрөнгийг акталсан, тайлант хугацааны элэгдлийн зардал 12,767.9 сая төгрөг байна.

Биет бус хөрөнгө дансны үлдэгдэл 362,051.4 сая болж 2,018.9 сая төгрөгөөр өссөн нь нислэгийн зөөврийн тоног төхөөрөмжийн программ, Microsoft ашиглах эрх, газар эзэмших эрх, мэдээллийн аюулгүй байдлыг хангах тоног төхөөрөмжийн программ хангамж ашиглах эрхийг шинээр 2,059.2 сая төгрөгөөр худалдан авснаас шалтгаалжээ. ТӨБЗГ-ын 2021 оны 325 дугаар тогтоолоор 40.3 сая төгрөгийн биет бус хөрөнгийг акталсан байна.

Дуусаагүй барилга дансны үлдэгдэл 497.3 сая болж 4,126.6 сая төгрөгөөр буурсан нь шалгалтын нислэгийн зөөврийн төхөөрөмжийг суурьлуулж, ашиглалтанд оруулснаас шалтгаалжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд хувь хүний орлогын албан татварын 40.8 сая, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын 0.6 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр 173.7 сая төгрөг байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд системийн өглөг 2,095.8 сая, бусад өр төлбөр 443.4 сая, урьдчилж орсон орлого 36.4 сая, татварын өр 209.5 сая, дансны өглөг 57.9 сая нийт 2,843.1 сая төгрөгийн өр төлбөр байна. Нийт өр төлбөрийн 2,189.3 сая төгрөгийн өр төлбөр нь Буянт-Ухаа Олон улсын нисэх буудлын үйл ажиллагаа зогссонтой холбоотой үүсжээ.

УОО-Урт хугацаат хөрөнгө оруулалт дансанд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн 5,408.9 сая төгрөгийн үндсэн хөрөнгө Иргэний нисэхийн ерөнхий газраас систем хооронд шилжиж ирсэн байна.

Эздийн өмч дансны үлдэгдэл 550,854.4 сая төгрөг болж 18,264.1 сая төгрөгөөр буурсан нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 370 дугаар

тогтоолоор МИАТ ТӨХК-ийн 9,273.3 сая төгрөгийн авлагыг чөлөөлснөөр тайлант үеийн алдагдлыг өсгөсөн нь нөлөөлжээ.

Шалгагдагч байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт бүртгэлийн бодлогоор өртөг, зардлыг хүлээн зөвшөөрөх, зардлыг зохих хариуцлагын төвөөр үнэн зөв хуримтлуулан бүртгэх, хуваарилах, тайлант хугацаанд хамаарах хэсгийг хүлээн зөвшөөрч тусгахаар заасан байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал гэж ангилсан байна.

Үйл ажиллагааны зардал 2,923.7 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 1,072.3 сая төгрөгөөр буурсан нь Монгол улсын Засгийн газрын 388 дугаар тогтоолын дагуу зардлыг бууруулж ажиллах, цахим хэлбэрт шилжих, улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу ажилчдыг зайнаас ажиллуулсан зэрэгтэй холбогдуулан цалингийн зардал буурсан нь шалтгаалжээ.

Үйлдвэрлэсэн болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг 112,811.7 сая төгрөг болж өмнөх онтой харьцуулахад 8,607.9 сая төгрөгөөр буурсан нь Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын 2021 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн А/86 дугаар тушаалын дагуу Буянт ухаа олон улсын нисэх буудлын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагаа Чингис хаан ОУНБ-д шилжсэнтэй холбоотой цалин, нийгмийн даатгал, урсгал зардлууд буурсан байна.

#### **4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Засгийн газрын агентлагийн эрхзүйн байдлын тухай хуулийн дагуу Иргэний нисэхийн ерөнхий газар нь засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг бөгөөд түүний зохион байгуулалтын бүтцэд Иргэний нисэхийн үндэсний төв байдаг.

Зам, тээврийн хөгжлийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2021 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн А/161/182 дугаар тушаалаар тус төвийн орлого, зарлагын төлөвлөгөөнд нэмэлт, өөрчлөлтийг оруулж орлогыг 237,464.1 сая төгрөг, зарлагыг 162,538.5 сая төгрөгөөр баталсан байна.

Үүнээс Иргэний нисэхийн ерөнхий газраас төсвийн хуваарилалтаар Иргэний нисэхийн үндэсний төв 8,206.3 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн, 140,393.9 сая төгрөгийн урсгал зардлыг захиран зарцуулж, зөрүү зарлагын эх үүсвэрийг Иргэний нисэхийн ерөнхий газраас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Тайлант жилийн эцсийн гүйцэтгэлээр нийт 8,578.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэн, 119,819.5 сая төгрөгийн санхүүжилт авч, 107,624.8 сая төгрөгийн урсгал зардал гарсан байна.

ИНҮТ-ийн орлогын гүйцэтгэл 8,578.5 сая төгрөг болж төлөвлөснөөс 372.2 сая төгрөг буюу 4.5 хувиар давсан буулт хөөрөлтийн орлого болон бусад орлогын өсөлт голлон нөлөөлсөн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 107,624.8 сая төгрөг болж, төлөвлөснөөс 32,769.1 сая төгрөг буюу 23.3 хувиар дутуу гүйцэтгэлтэй гарсан байна. Ковид 19 цар тахлаас шалтгаалан үйл ажиллагаа тасалдаж зардал бага зарцуулсантай холбоотой байна.

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Иргэний нисэхийн үндэсний төв нь тайлант онд нийт 311,712.3 сая төгрөгийн 2,664 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 98 мэдээллийг байршуулаагүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.

### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 27,222.4 сая төгрөгийн 128 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгагдсан байна. Үүнээс Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1, 1.4 дэх заалтын дагуу 2,667.4 сая төгрөг бүхий 20 төсөл арга хэмжээг 2022 онд хэрэгжүүлэхээр хойшлуулсан байна.

Тайлант хугацаанд нийт 108 төсөл арга хэмжээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, төрийн худалдан авах ажиллагааны [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим системд давхардсан тоогоор 167 удаа тендер зарлан, үр дүнг тухай бүрд системд оруулж ажилласан байна. Сонгон шалгаруулалтаар гэрээ байгуулж бүрэн хэрэгжсэн 74 төсөл арга хэмжээ байна.

Тендер шалгаруулалтын захиалагчийн гаргасан шийдвэрт оролцогчдын зүгээс Сангийн яаманд нийт 7 гомдол гарснаас 5 тендерт дахин үнэлгээ хийсэн, 1 гомдол шүүхэд шилжсэн, 1 гомдол шийдвэрлэгдээгүй байна.

Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газарт 3 гомдол гарснаас 1 гомдол нь өрсөлдөөн хязгаарласан шийдвэртэй, 2 гомдол нь өрсөлдөөн хязгаарлаагүй гэж үзсэн байна. Захиргааны хэргийн шүүхэд 1 гомдол шийдвэрлэгдээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

**6. ЗАВСРЫН АУДИТЫН ҮР ДҮН, ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ**

Завсрын аудитаар 880.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж, аудитын явцад биет бус хөрөнгөнд бүртгээгүй 127.2 сая төгрөг, НӨАТ-ын хуулийн хэрэгжилттэй холбоотой 676.2 сая төгрөг, анхан шатны баримтын иж бүрдэл и баримтгүй бараа, ажил үйлчилгээ худалдан авсан 74.5 сая төгрөг нийт 877.9 сая төгрөгийн зөрчлийг залруулж, ажилчдын илүү цагийн хөлсийг тооцохдоо цагийн тарифыг буруу тооцож илүү олгосон 2.0 сая төгрөгийг ажилчдаас суутган алдааг залруулсан болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 280.0 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт 6.1 сая төгрөг, 164.0 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага хүргүүлж, 109.9 сая төгрөгийн зөрчилд 11 зөвлөмж өгснөөс акт 100 хувь, албан шаардлага 80.9 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

*Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт*

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	6.1	1	6.1	-	-	100.0
Албан шаардлага	10	164.0	9	132.6	1	31.4	80.9
Зөвлөмж	11	109.9	11	109.9	-	-	100.0
Нийт дүн	22	280.0	21	248.6	1	31.4	88.8

Нэр бүхий хоёр ажилтанд шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх зөрчлийг арилгах албан шаардлагыг хэрэгжүүлээгүй талаар дараагийн аудитаар анхаарах асуудалд оруулсан.

**7. Дараагийн аудитаар анхаарах асуудал**

ТӨБЗГ-ын 2019 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн 382 дугаар тогтоолоор Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай шийдвэрийн дагуу Япон Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө болон Монгол Улсын засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлсэн Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын нийт 1,264,630.6 сая төгрөгийн хөрөнгөөс Иргэний нисэхийн үндэсний төвтэй холбоотой хөрөнгийг хүлээн авч бүртгэсэн эсэхийг нягтлан шалгах.

Өмнөх аудитаар ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий 2 ажилтанд олгосон хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авах албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, мөн тайлант хугацаанд давтан нэр бүхий 3 ажилтанд 31.7 сая төгрөгийг нөхөн олговрыг олгож буруутай албан тушаалтнаар төлүүлээгүй зэрэг асуудалд Иргэний нисэхийн ерөнхий газар болон Зам, тээврийн хөгжлийн яамны дотоод аудитаас тодорхой арга хэмжээ авч хэрхэн шийдвэрлэсэн талаар дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй байна.

**8. Аудитын илрүүлэлт**

Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд Иргэний нисэхийн үндэсний төв, Буянт ухаа Олон улсын нисэх буудал, Сэргээн засах амралт, 13 аймаг дахь орон нутгийн нисэх буудал, Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны санхүүгийн тайланг нэгтгэсэн байна.



Аудитаар Иргэний нисэхийн үндэсний төв болон Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын алба, Холбоо, навигаци, ашиглалтын албаны санхүүгийн тайланг түүвэрт хамруулсан.

Тус төвийн санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдаж байгаа Ховд аймаг дахь нисэх буудал “Хязгаарлалттай” дүгнэлт, Сэргээн засах амралтын газар “Татгалзсан” дүгнэлт, Буянт-Ухаа ОУНБ, Өвөрхангай, Увс, Баян-Өлгий, Өмнөговь, Завханы Тосонцэнгэл, Отгонтэнгэр, Баянхонгор, Говь-Алтай, Хөвсгөл, Дорнод аймаг дахь нисэх буудал болон 11 аймгийн орон нутгийн нисэх буудлын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Өвөрхангай, Ховд, Увс, Завхан аймгийн Тосонцэнгэл, Отгонтэнгэр зэрэг аймгуудын нисэх буудлын газруудад санхүүгийн тайлангийн аудитаар зөрчил илрээгүй байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 246,926.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 246,461.6 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 21.8 сая төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 356.2 сая төгрөгийн зөрчилд 8 албан шаардлага хүргүүлж, 1 зөрчилд сахилгын хариуцлага тооцож, 86.5 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 11 зөвлөмж өглөө. Үүнээс

- Иргэний нисэхийн үндэсний төвийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 246,587.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 246,425.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 10.6 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 151.1 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж;
- Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 339.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 36.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 11.2 сая төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт, 205.1 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 1 зөрчилд сахилгын хариуцлага тооцох, 86.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 8 зөвлөмж;

## **Санхүүгийн нэгтгэсэн тайлан**

### **8.1 Залруулсан алдаа**

Иргэний нисэхийн үндэсний төвийн нэгтгэсэн тайлангаар санхүүгийн байдлын тайлангийн эздийн өмчийн бусад хэсэг дансны эцсийн үлдэгдэл 2,001.0 сая, хуримтлагдсан ашиг дансны эцсийн үлдэгдэл 138,211.4 сая төгрөгөөр тус тус буруу илэрхийлэгдсэн, үндсэн хөрөнгийн тодруулга тайланд алба хооронд шилжүүлсэн хөрөнгийн дотоод хөдөлгөөнийг оруулж тайлагнасан 106,212.8 сая, Говь-Алтай аймаг дахь “Алтай” нисэх буудлын татварын тодорхойлолтоор илүү тайлагнасан 16.9 сая, Өнө-Алтай ХХК-тай байгуулсан гэрээний төлбөрийг зардлаар бүртгэсэн 19.4 сая төгрөг байна

Энэ нь санхүүгийн тайлангийн үнэлгээ ба хуваарилалт, иж бүрэн байх, эрх ба үүрэг толилуулга батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: 2021 оны санхүүгийн тайланд залруулга хийлгэсэн.

### **8.2 Төлбөрийн акт**

Нэр бүхий 9 ажилтанд нэгээс дээш жилийн насжилттай олгосон урьдчилгаа цалингийн 3.2 сая төгрөг, илүү цагийн тооцооллын алдаанаас үүссэн 0.4 сая төгрөг, ажлаас гарсан 13 ажилтны ээлжийн амралтын тооцоог хийгээгүйгээс үүссэн 6.6 сая төгрөг, нэг ажилтны дараа тооцоогоор үүссэн шатахууны 0.4 сая төгрөг нийт 10.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчим”, 18 дугаар зүйлийн 18.1 “нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах”, Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.3 “Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

### 8.3 Албан шаардлага

1. УБ хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл хэрэгжүүлэх нэгжид ашиглагдаж байсан хөрөнгийг Иргэний нисэхийн үндэсний төв хүлээн авч акт үйлдсэн боловч балансад бүртгэж аваагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, Сангийн сайдын 2021 оны 4 тоот тушаалаар батлагдсан журамтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Тайлант хугацаанд ажлаас үндэслэлгүй халагдсан нэр бүхий ажилтанд шүүхийн шийдвэрээр ажилгүй байсан хугацааны нөхөн олговор 14.9 сая төгрөгийг байгууллагаас олгосон боловч байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ”, 103.2-т “Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

### 8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

##### 1.1 Илрүүлэлт:

Иргэний нисэхийн үндэсний төвийн хэмжээнд ажлын цагийг нэгтгэн тооцох заавар, аргачлал, тооцооллын нэгдсэн хүснэгт байхгүйгээс цагийн нэгтгэлийг буруу хийх, цалингийн тооцооллын алдаа гарах эрсдэлтэй байна.

##### 1.2 Өгсөн зөвлөмж:

Иргэний нисэхийн үндэсний төвийн хэмжээнд цагийн бүртгэлийн маягт болон цагийг нэгтгэн тооцох зааврыг баталж хэрэгжүүлэх

##### 2.1 Илрүүлэлт:

Зохион байгуулалтын бүтцээр шилжиж байгаа болон ажлаас чөлөөлөгдөж байгаа ажилчидтай тойрох хуудсаар тооцоо хийгээгүйгээс эзэн холбогдогчгүй авлага үүсэж байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:**

Захиргаа хүний нөөцийн албанаас сар бүр ажилчдын мэдээллийг авч санхүүгийн программын цалингийн модулд тогтмол мэдээллийг оруулж байх, ажлаас чөлөөлөгдсөн болон зохион байгуулалтын өөрчлөлтөөр систем дотор хөдөлгөөн хийгдсэн ажилчидтай тооцоо бодож тойрох хуудсаар хяналтыг тогтмол хийж хэвших.

**3.1 Илрүүлэлт**

Санхүүгийн программын хөгжүүлэлт, тохируулгыг тухай бүр хийдэггүй, программын хэрэглэгчийн эрх хязгаарлалтын хяналт сул, санхүүгийн мэдээллийн аюулгүй байдал, тайлант үеийн хаалт, санхүүгийн тайлан, тодруулгын дүн буруу татагдах алдаа давтагдан гарч байна.

**3.2 Өгсөн зөвлөмж:**

Санхүүгийн программын хөгжүүлэлт, шинэчлэлтийг тогтмол хийх, программын хэрэглэгчийн тохируулгыг хийж залруулга, устгалт хийсэн хэрэглэгчийн бүртгэлийг хөтөлж хяналт тогтмол тавьж хэвших.

**Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан**

Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайланд нэгтгэгддэг харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд аудитаар илрүүлсэн, залруулаагүй материаллаг алдаа зөрчлийг дурдвал:

1. Сэргээн засах амралтын санхүүгийн тайлангийн аудитад 655.8 сая төгрөгийн касс, харилцахын баримт, 346.5 сая төгрөгийн бараа материалын тайлан, 2,388.6 сая төгрөгийн хөрөнгийн тооцоо бодсон акт, худалдан авах ажиллагааны 544.4 сая төгрөгийн баримтуудыг ирүүлээгүй, санхүүгийн тайлан, тодруулга иж бүрэн бус, ерөнхий журнал, гүйлгээ балансын дүнгүүд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдээс зөрүүтэй, авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй зэргийн улмаас санхүүгийн тайлангууд бүхэлдээ буруу илэрхийлэгдэж, санхүүгийн тайланд аудитын дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.
2. Баянхонгор аймаг дахь нисэх буудлын дараагийн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөгдөх тээврийн хэрэгслийн даатгалын 1.6 сая төгрөгийг урьдчилж төлсөн зардал дансанд бүртгээгүй, худалдан авсан бараа ажил, үйлчилгээний баримт нь и-баримтаар баталгаажаагүй 21.2 сая төгрөг, шилэн дансны цахим сайтад 33.8 сая төгрөгийн зарлагын 4 гүйлгээг мэдээлээгүй байна.
3. Говь-Алтай аймаг дахь нисэх буудал нь урамшуулалт цалинг 0.1 сая төгрөгөөр илүү олгосон, 3.1 сая төгрөгийн авлага, 1.5 сая төгрөгийн өглөгийг барагдуулаагүй, тайланд оны цалингийн зардал, татварын тайлан дахь цалингийн зардал 0.7 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.
4. Сүхбаатар аймаг дахь Баруун-Урт нисэх буудлын үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 142 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна. Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээллийг байршуулаагүй байна.
5. Ховд аймаг дахь нисэх буудал нь бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа анхан шатны баримтын бүрдэлгүй төлбөр хийгдсэн, байгууллагын даргад утасны төлбөр олгосон, байгууллагын орон сууцад амьдарч байгаа хувь хүмүүстэй гэрээ байгуулаагүй, дотоод хяналтын ажлын төлөвлөгөөнд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тусгаагүй, томилолтын тооцоо хийгээгүй, шатахууны урамшуулал бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас олгосон ч эд хариуцагч нь бараа

материалын тайланд орлогоор бүртгээгүй нийт 141.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тайлант онд 175.4 сая төгрөгийн шатахуун, нүүрсний худалдан авалтыг Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан байна.

6. Хөвсгөл аймаг дахь нисэх буудлын санхүүгийн тайланд тусгагдсан Аэро Монголиа ХХК 2.0 сая төгрөг, Хүннү Эйр ХХК 4.6 сая төгрөгийн авлагыг барагдуулаагүй, 2021 онд БОАЖЯ-ны сайдын багцаас хийсэн 39.6 сая төгрөгийн зорчигчийг угтах заалны засварын ажлыг хүлээж авсан данс бүртгэлд тусгаагүй байна.
7. Дорнод аймаг дахь нисэх буудал нь шилэн дансны цахим хуудсанд 5.0 сая төгрөгөөс дээш 41.4 сая төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.
8. Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал тайлант хугацаанд 291 ажилтны ээлжийн амралтын тооцоог бодож олгохдоо амралтын хоног 74.2 сая төгрөгийн хоолны нөхөн олговрыг тооцсон, нэр бүхий 21 байгууллага, хувь хүний 27.1 сая төгрөгийн авлага, 2 байгууллагын 4.9 сая төгрөгийн өглөгийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Шилэн дансны цахим хуудсанд 16 төрлийн 9,032.3 сая төгрөгийн 140 мэдээ ил тод байршуулахаас 1,041.2 сая төгрөгийн 3 мэдээг хугацаа хоцроосон байна.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс								
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо
<b>Иргэний нисэхийн үндэсний төвийн санхүүгийн тайлан</b>															
<b>Санхүүгийн тайлангийн асуудлаар</b>															
1	Иргэний нисэхийн үндэсний төв	АХГ-2022/18/НА-СТА-ТӨА	2021 оны санхүүгийн байдлын тайлангийн эздийн өмчийн хэсгийн дүнг хойшлогдсон орлого дансанд тайлагнасан.	Холбогдох хууль, тогтоомж, стандартын дагуу санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх	1	2,001,019.6	1	2,001,019.6	-	-	-	-	-	-	-
2	Иргэний нисэхийн үндэсний төв	АХГ-2022/18/НА-СТА-ТӨА	2021 оны өмчийн өөрчлөлтийн тайлангийн хуримтлагдсан ашгийн дүн өмчид гарсан өөрчлөлтийн дүнгээс буруу татагдсан.	Холбогдох хууль, тогтоомж, стандартын дагуу санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх	1	138,211,412.1	1	138,211,412.1	-	-	-	-	-	-	-
3	Иргэний нисэхийн үндэсний төв	АХГ-2022/18/НА-СТА-ТӨА	Санхүүгийн тайлангийн тодруулгад алба хооронд шилжүүлсэн хөрөнгийн дотоод хөдөлгөөнийг оруулж тайлагнасан байна.	Холбогдох хууль, тогтоомж, стандартын дагуу санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх	1	106,212,832.9	1	106,212,832.9	-	-	-	-	-	-	-
4	Иргэний нисэхийн үндэсний төв	АХГ-2022/18/НА-СТА-ТӨА	УБ хотын ОУ-ын нисэх онгоцны шинэ буудал барих төсөллийн нэгжид ашиглагдаж байсан хөрөнгийг ИНҮТ хүлээн авсан боловч балансд бүртгэж аваагүй байна.	Хүлээж авсан хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу балансд бүртгэж, тайлагнах	1	136,203.3	-	-	-	-	1	136,203.3	-	-	-

Иргэний нисэхийн үндэсний төв 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

5	Иргэний нисэхийн үндэсний төв	АХГ-2022/18/НА-СТА-ТӨА	Тайлант онд шүүхийн тогтоолоор нийт 14,925.0 мянган төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий дөрвөн ажилтанд олгосон боловч байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлээгүй байна.	Захиргааны ерөнхий хуулийн дагуу нөхөн олговрыг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх	1	14,925.0	-	-	-	-	1	14,925.0	-	-	-	-
6	Иргэний нисэхийн үндэсний төв	АХГ-2022/18/НА-СТА-ТӨА	Нэгээс дээш жилийн насжилттай нэр бүхий 9 ажилтанд олгосон урьдчилгаа цалингийн 3,201.6 мянга, нэр бүхий ажилтны илүү цагийн тооцооллын алдаанаас үүссэн 380.9 мянга, ажлаас гарсан нэр бүхий 13 ажилтны ээлжийн амралтын тооцоог хийгээгүйгээс үүссэн 6,607.5 мянга, нэр бүхий ажилтны дараа тооцоогоор үүссэн шатахууны 400.0 мянга, нийт 10,589.9 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуулийг мөрдөж ажиллах	1	10,589.9	-	-	1	10,589.9	-	-	-	-	-	-
7	Иргэний нисэхийн үндэсний төв	АХГ-2022/18/НА-СТА-ТӨА	ИНҮТ-ийн хэмжээнд ажлын цагийг нэгтгэн тооцох заавар, аргачлал, тооцооллын нэгдсэн хүснэгт байхгүйгээс цагийн нэгтгэлийг буруу хийх, цалингийн тооцооллын алдаа гарах эрсдэлтэй байна.	Иргэний нисэхийн үндэсний төвийн хэмжээнд цагийн бүртгэлийн маягт болон цагийг нэгтгэн тооцох зааврыг баталж хэрэгжүүлэх	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-

**Иргэний нисэхийн үндэсний төв 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

8	Иргэний нисэхийн үндэсний төв	АХГ-2022/18/НА-СТА-ТӨА	Зохион байгуулалтын бүтцээр шилжиж байгаа болон ажлаас чөлөөлөгдөж байгаа ажилчидтай тойрох хуудсаар тооцоо хийгээгүйгээс эзэн холбогдогчгүй авлага үүсэж байна.	Ажлаас чөлөөлөгдсөн болон зохион байгуулалтын өөрчлөлтөөр систем дотор хөдөлгөөн хийгдсэн ажилчидтай тооцоо бодож тойрох хуудсаар хяналтыг тогтмол хийж хэвших	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	
9	Иргэний нисэхийн үндэсний төв	АХГ-2022/18/НА-СТА-ТӨА	Санхүүгийн програмын хөгжүүлэлт, тохируулгыг тухай бүр хийдэггүй, програмын хэрэглэгчийн эрхийн хязгаарлалтын хяналт сул, санхүүгийн мэдээллийн аюулгүй байдал, тайлант үеийн хаалт, санхүүгийн тайлан, тодруулгын дүн буруу татагдах алдаа давтагдан гарч байна.	Санхүүгийн програмын хөгжүүлэлт, шинэчлэлтийг тогтмол хийх, програмын хэрэглэгчийн тохируулгыг хийж залруулга, устгал хийсэн хэрэглэгчийн бүртгэлийг хөтөлж хяналт тогтмол тавьж хэвших	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	
<b>ДҮН</b>					<b>9</b>	<b>246,586,982.8</b>	<b>3</b>	<b>246,425,264.6</b>	<b>1</b>	<b>10,589.9</b>	<b>2</b>	<b>151,128.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>-</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудлаар</b>																
10	Иргэний нисэхийн үндэсний төв	АХГ-2022/18/НА-СТА-ТӨА	Тайлант онд нийт 311,712.3 сая төгрөгийн 2,664 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 98 мэдээллийг байршуулаагүй, 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	
<b>ДҮН</b>					<b>1</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>-</b>	
<b>Иргэний нисэхийн үндэсний төвийн нийт дүн</b>					<b>10</b>	<b>246,586,982.8</b>	<b>3</b>	<b>246,425,264.6</b>	<b>1</b>	<b>10,589.9</b>	<b>2</b>	<b>151,128.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>4</b>	<b>-</b>
<b>Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлан</b>																

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн асуудлаар																
11	Сэргээн засах амралт		Сэргээн засах амралтын санхүүгийн тайлангийн аудитад касс, харилцахын баримт, бараа материалын тайлан, хөрөнгийн тооцоо бодсон акт, худалдан авах ажиллагааны баримтуудыг ирүүлээгүй, санхүүгийн тайлан, тодруулга иж бүрэн бус, ерөнхий журнал, гүйлгээ балансын дүнгүүд санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдээс зөрүүтэй, авлага, өглөгийн дэлгэрэнгүй бүртгэл хөтлөөгүй, тооцоо нийлсэн акт үйлдээгүй зэргийн улмаас санхүүгийн тайлангууд бүхэлдээ буруу илэрхийлэгдэж, санхүүгийн тайланд аудитын дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.	Зөрчил гаргасан нягтлан бодогч Б.Баттуяад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
12	Баянхонгор аймаг дахь нисэх буудал	БНА-2022/1/НА-СТА-ТӨҮГ	Баянхонгор аймаг дахь нисэх буудлын дараагийн тайлант хугацаанд хүлээн зөвшөөрөгдөх тээврийн хэрэгслийн даатгалын 1,614.3 мянган төгрөгийг урьдчилж төлсөн зардал дансанд бүртгээгүй байна.	Гэрээний дагуу урьдчилж төлсөн зардлыг хүлээн зөвшөөрөгдөх хугацаагаар нь бүртгэж тайлагнах	1	1,614.3	-	-	-	-	-	-	-	-	1	1,614.3



## Иргэний нисэхийн үндэсний төв 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

13	Баянхонгор аймаг дахь нисэх буудал	БНА-2022/1/НА-СТА-ТӨҮГ	Тайлант хугацааны худалдан авсан бараа ажил, үйлчилгээ нь төлбөрийн и баримтаар баталгаажуулж, анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
14	Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал	ГАА-2022/01/-НА-СТА-ТӨҮГ	Татварын тодорхойлолтоор 84.5 мянган төгрөгийн дутуу, 1,296.3 мянган төгрөгийн илүү төлөлттэй боловч санхүүгийн тайланд тусгаагүй.	Татварын тайлангийн авлага, өглөгийг санхүүгийн тайлангийн авлага, өглөгтэй тулган баталгаажуулж байх	1	1,380.8	-	-	-	1	1,380.8	-	-	-	-	-
15	Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал	ГАА-2022/01/-НА-СТА-ТӨҮГ	Тайлант оны эцэст санхүүгийн тайланд тусгасан 3,109.1 мянган төгрөгийн авлага 1,541.0 мянган төгрөгийн өглөгийг барагдуулах талаар тодорхой ажил зохион байгуулаагүй.	Санхүүгийн тайланд тусгасан авлага, өглөгийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах	1	4,650.1	-	-	-	1	4,650.1	-	-	-	-	-
16	Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал	ГАА-2022/01/-НА-СТА-ТӨҮГ	Тайланд онд олговол зохих нийт цалингийн зардал, татварын тайлангийн татвар ногдох цалингийн орлогоос 730 мянган төгрөгөөр зөрүүтэй байна.	Хувь хүний орлогын албан татвар, Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах	1	730.0	-	-	-	1	730.0	-	-	-	-	-
17	Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал	ГАА-2022/01/-НА-СТА-ТӨҮГ	Татварын тодорхойлолтоор 16,930.4 мянган төгрөгийн илүү төлөлттэй байсныг залруулсан.	Холбогдох хууль, тогтоомж, стандартын дагуу санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх	1	16,930.4	1	16,930.4	-	-	-	-	-	-	-	-

Иргэний нисэхийн үндэсний төв 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

18	Говь-Алтай аймаг дахь "Алтай" нисэх буудал	ГАА-2022/01/НА-СТА-ТӨҮГ	Өнө Алтай ХХК-тай байгуулсан гэрээний дагуу төлбөрийг зардлаар бүртгэснийг урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэж залруулсан.	Холбогдох хууль, тогтоомж, стандартын дагуу санхүүгийн тайланг үнэн зөв бэлтгэх	1	19,373.3	1	19,373.3	-	-	-	-	-	-	-	-
19	Сүхбаатар аймаг дахь Баруун-Урт нисэх буудал	СБА-2022/01/НА-СТА-ТӨА	Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг эдийн засгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоогоогүйгээс санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үлдэх өртөггүй 142 ширхэг хөрөнгө бүртгэлтэй байна.	Үндсэн хөрөнгийн эдийн засгийн нас буюу ашиглах хугацааг тухайн хөрөнгийн өгөөжтэй уялдуулан зөв тогтоож УСНББОУС 17 Үндсэн хөрөнгийн 67 дугаар зүйлийг мөрдөж ажиллах	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
20	Ховд аймаг дахь нисэх буудал	ХОА-2022/03/НА-СТА-ТӨА	Тайлант онд худалдан авсан бараа ажил үйлчилгээ нь төлбөрийн и баримтаар баталгаажаагүй, анхан шатны баримтын иж бүрдэл хангалтгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах	1	26,260.9	-	-	-	-	-	-	-	-	1	26,260.9
21	Ховд аймаг дахь нисэх буудал	ХОА-2022/03/НА-СТА-ТӨА	Үр дүнгийн урамшуулалыг сар бүр байгууллагын дарга, нягтлан бодогчид олгосон, байгууллагын даргад сар бүр утасны төлбөр 30.0 мянган төгрөг олгосон байна.	Засгийн газрын 2016 оны 47 дугаар тогтоол "албан тушаалтны гар утасны зардлыг төсвөөс санхүүжүүлэхгүй байх" гэж заасныг мөрдөж ажиллах	1	12,405.2	-	-	-	-	-	-	-	-	1	12,405.2

Иргэний нисэхийн үндэсний төв 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

22	Ховд аймаг дахь нисэх буудал	ХОА-2022/03/НА-СТА-ТӨА	Байгууллагын ажилчдын орон сууцанд хөдөлмөрийн гэрээ дуусгавар болсон ажилчид амьдарч байгаа бөгөөд байр эзэмшиж байгаа ажилчидтай гэрээ байгуулаагүй байна.	ИНЕГ-ын хөдөлмөрийн дотоод журмын дагуу орон сууцыг түр эзэмшиж байгаа ажилчидтай гэрээ байгуулах	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
23	Ховд аймаг дахь нисэх буудал	ХОА-2022/03/НА-СТА-ТӨА	Дотоод хяналтын ажлын төлөвлөгөөнд санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой асуудлыг тусгаагүй, томилолтын мөнгө олгохдоо анхан шатны баримт хангалтгүй, томилолтын хуудсыг байгууллагын удирдлагаар хаалт хийлгээгүй, ирсэн буцсан өдөр засвартай, Бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан бараа, ажил үйлчилгээ нь анхан шатны баримтаар баталгаажуагүй, Тайлант онд хамтран ажиллах гэрээ, бусад холбогдох баримтгүй үнс зайлуулсны ажлын хөлс олгосон байна.	Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын дагуу байгууллагын онцлогт тохирсон Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журамтай байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах	1	92,092.6	-	-	-	1	92,092.6	-	-	-	-	-
24	Ховд аймаг дахь нисэх буудал	ХОА-2022/03/НА-СТА-ТӨА	Тайлант онд нэр бүхий ажилчдыг томиллолтоор ажилласныг нотлох баримтгүй томилолтын мөнгө, тушаал, шийдвэргүй нэмэгдэл цалин олгосон олгосон байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах	1	6,460.8	-	-	1	6,460.8	-	-	-	-	-	-

Иргэний нисэхийн үндэсний төв 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

25	Ховд аймаг дахь нисэх буудал	ХОА-2022/03/НА-СТА-ТӨА	Булган сумын техникч ээлжийн амралттай хугацаанд тухайн үед томилолтоор ажилласан хугацааны томилолтын 1,500.0 мянган төгрөгийг олгоогүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах	1	1,500.0	-	-	1	1,500.0	-	-	-	-	-	-
26	Ховд аймаг дахь нисэх буудал	ХОА-2022/03/НА-СТА-ТӨА	Шатахууны урамшуулал бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас олгосон ч эд хариуцагч нь бараа материалын тайланд орлогоор бүртгээгүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу анхан шатны баримтын иж бүрдлийг хангаж ажиллах	1	3,197.4	-	-	1	3,197.4	-	-	-	-	-	-
27	Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудал	ХӨА-2022/01/НА-СТА-ТӨА	Нэгээс дээш жилийн насжилттай Аэро Монголиа ХХК-иас авах 2,000.0 мянган төгрөг, Хүннү Эйр ХХК-иас авах 4,600.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй байна.	Нэгээс дээш жилийн насжилттай авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах	1	6,645.8	-	-	-	-	-	-	-	-	1	6,645.8
28	Хөвсгөл аймаг дахь Мөрөн нисэх буудал	ХӨА-2022/01/НА-СТА-ТӨА	2021 онд БОАЖЯ-ны сайдын багцаас хийсэн зорчигчийг угтах заалны засварын ажлыг хүлээж авсан боловч бүртгэлд тусгаагүй байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу хүлээж авсан хөрөнгийг балансад бүртгэж, тайлагнах	1	39,556.9	-	-	-	-	-	-	-	-	1	39,556.9
29	Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал	АХГ-2022/19/НА-СТА-ТӨА	Тайлант хугацаанд 291 ажилтны ээлжийн амралтын тооцоог бодож олгохдоо амралтын хоногт 74,184.0 мянган төгрөгийн хоолны нөхөн олговрыг тооцсон.	Хөдөлмөрийн тухай хууль, Дундаж цалин, хөлс тодорхойлох журмыг мөрдөж ажиллах	1	74,184.0	-	-	-	1	74,184.0	-	-	-	-	-

**Иргэний нисэхийн үндэсний төв 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

30	Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал	АХГ- 2022/19/НА- СТА-ТӨА	Тайлант хугацаанд 21 байгууллага, хувь хүний 27,104.8 мянган төгрөгийн авлага, 2 байгууллагын 4,987.3 мянган төгрөгийн өглөгийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулаагүй.	Нягтлан бодох бүртгэлийн дагуу авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулан, барэгдуулах талаар арга хэмжээ авч ажиллах	1	32,092.1	-	-	-	-	1	32,092.1	-	-	-	-
<b>ДҮН</b>					<b>20</b>	<b>339,074.6</b>	<b>2</b>	<b>36,303.7</b>	<b>3</b>	<b>11,158.2</b>	<b>6</b>	<b>205,129.6</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>8</b>	<b>86,483.1</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал</b>																
31	Баянхонгор аймаг дахь нисэх буудал	БНА- 2022/1/НА- СТА-ТӨҮГ	Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 33,797.4 мянган төгрөгийн зарлагын 4 гүйлгээг мэдээлээгүй байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	33,797.4	-	-	-	-	1	33,797.4	-	-	-	-
32	Сүхбаатар аймаг дахь Баруун-Урт нисэх буудал	СБА- 2022/01/НА- СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээллийг мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлтэй нийцэхгүй байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	-	-	-	-	-	-	-	-	-	1	-
33	Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал	АХГ- 2022/19/НА- СТА-ТӨА	Шилэн дансны цахим хуудсанд 16 төрлийн 9,032,343.5 мянган төгрөгийн 140 мэдээ ил тод байршуулахаас 1,041,214.1 мянган төгрөгийн 3 мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	-	-	-	-	-	-	-	1	-	-	-
34	Дорнод аймгийн Чойбалсан нисэх буудал		Шилэн дансны цахим хуудсанд 5 сая төгрөгөөс дээш 41,438.9 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-

Иргэний нисэхийн үндэсний төв 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

35	Ховд аймаг дахь нисэх буудал Ховд аймаг дахь нисэх буудал	ХОА-2022/03/НА-СТА-ТӨА ХОА-2022/03/НА-СТА-ТӨА	Тайлант онд шатахуун худалдан авахдаа холбогдох хуульд заасан ажиллагааны журам мөрдөөгүй, Тендерийн урилга нээлттэй мэдээлснийг нотлох баримтгүй, шууд гэрээ байгуулсан, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан, нүүрсний тээвэр хийгдээгүй аж ахуйн нэгж байгууллагаас худалдан авсан, эд хариуцагчийн нэрээр мөнгө гаргаж, нүүрс авсан байна.	ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах ТБОНӨХБАҮХА тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах	1	175,417.1	-	-	-	-	-	-	-	1	175,417.1	
<b>ДҮН</b>					<b>5</b>	<b>209,214.5</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>33,797.4</b>	<b>1</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>175,417.1</b>	
<b>Харьяа байгууллагуудын нийт дүн</b>					<b>25</b>	<b>548,289.1</b>	<b>2</b>	<b>36,303.7</b>	<b>3</b>	<b>11,158.2</b>	<b>8</b>	<b>238,927.0</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>10</b>	<b>261,900.2</b>
<b>САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН НИЙТ ДҮН</b>					<b>35</b>	<b>247,135,271.9</b>	<b>5</b>	<b>246,461,568.3</b>	<b>4</b>	<b>21,748.1</b>	<b>10</b>	<b>390,055.3</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>14</b>	<b>261,900.2</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15 № 128/А0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/18/НА-СТА-ТӨА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Нэр бүхий 9 ажилтанд олгосон нэгээс дээш жилийн насжилттай урьдчилгаа цалингийн 3,201,552.50 төгрөг, нэг ажилтны илүү цагийн тооцооллын алдаанаас үүссэн 380,870.40 төгрөг, ажлаас гарсан 13 ажилтны ээлжийн амралтын тооцоо хийгээгүйгээс үүссэн 6,607,469.00 төгрөг, ажлаас гарсан нэг ажилтны дараа тооцоогоор үүссэн шатахууны 400,026.30 төгрөгийн авлагыг тус тус барагдуулаагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчим", 18 дугаар зүйлийн 18.1 "нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуй нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах", Хөдөлмөрийн тухай хуулийн 110 дугаар зүйлийн 110.3 "Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа нь дуусгавар болж байгаа ажилтанд ажилласан хугацаанд ногдох ээлжийн амралтын тооцоо хийж, цалинг олгоно" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Нэр бүхий ажилчдаас авах нийт 10,589,918.20 /арван сая таван зуун наян есөн мянга есөн зуун арван найм/ төгрөгийн авлагыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банканд дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга П.Мөнхжаргал, ерөнхий нягтлан бодогч С.Отгонбаяр нарт даалгав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Д.ГАНДОЛГОР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 542 /А0150458

Улаанбаатар хот

АХГ-2022/18/НН-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд

Тайлант онд шүүхийн тогтоолоор нийт 14,925,462.00 төгрөгийн ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг нэр бүхий ажилтанд олгосон боловч байгууллагад учирсан хохирлыг буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлээгүй байна.

Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1 "Иргэн хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага, Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ", 103.2 "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай албан тушаалтнаар хохирлыг төлүүлэх үүргийг тухай захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн

**ШААРДАХ нь:**

1. Нэр бүхий дөрвөн ажилтанд ажилгүй байсан хугацааны нөхөн олговорт олгосон нийт 14,925,462.00 /арван дөрвөн сая есөн зуун хорин таван мянга дөрвөн зуун жаран хоёр/ төгрөгийг шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын Дотоод аудитын албаны дарга Н.Мөнхсүрэнд даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ  
Д.ГАНДОЛГОР





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15

№ 541/А0150458

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн үндэсний төвийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд

Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих төсөл хэрэгжүүлэх нэгжид ашиглаж байсан 136,203,298.00 төгрөгийн хөрөнгийг Иргэний нисэхийн үндэсний төвд шилжүүлж хөрөнгө хүлээлцсэн акт үйлдсэн боловч төв нь балансанд бүртгэж аваагүй байна.


Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2 “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.7 “Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнана”, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга, хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журмын 12 дугаар зүйлийн 12.5 “Төсөл хэрэгжүүлэх нэгж нь хөрөнгийн бүртгэлийг Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн дагуу хөтөлж, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн явцад болон дуусгавар болсны дараа төсөл хэрэгжүүлэгч байгууллагад холбогдох дүрэм, журмын дагуу хүлээлгэн өгч, энэ тухай акт үйлдэн баталгаажуулсныг үндэслэн бүртгэл хөтөлж, цахим системээр тайлагнана” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, хөрөнгийг бүртгэн авч зөрчлийг арилган, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн дарга П.Мөнхжаргал, ерөнхий нягтлан бодогч С.Отгонбаяр нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АШИД БАЛАНС АУДИТЫН ХХК-ИЙН  
АХЛАХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
С.НАЦАГДОРЖ

Д.ГАНДОЛГОР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

9019120396

\\10.10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0315\_Auditin\_2\_Gazar-221.Docx

0001081420